



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨААТҮГ-ЫН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН

АУДИТЫН КОД: АХГ-2022/108/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Аудитор: Б.Энхжин
Утас: 260512 Цахим хаяг: enkhjinb@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн: “Си Пи Ти Эй Аудит” ХХК
Захирал: Ч.Энхчимэг
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaudit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
5.1 Шилэн дансны мэдээлэл	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
8. Аудитын илрүүлэлт	15
8.1 Залруулсан алдаа	16
8.2 Төлбөрийн акт	16
8.3 Албан шаардлага	17
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
НА	Нотлох ажил
НӨАТ	Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨААТҮГ	Төрийн өмчит Аж Ахуйн Тооцоот Үйлдвэрийн Газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
УИХ	Улсын Их Хурал
УЦС	Усан Цахилгаан Станц
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 08/580

танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитынхаа хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзэн, тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 680 дугаар тогтоолоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 5,041.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 5,035.2 сая төгрөгөөр, ашгийг 6.2 сая төгрөг байхаар баталсан байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 394 дүгээр тогтоолоор нийт орлогыг 1,009.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,003.6 сая төгрөг, ашгийг 5.9 сая төгрөгөөр тус тус бууруулж тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 3,428.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,620.4 сая төгрөгийн зардал гарган, 192.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компани 2021 онд 12 зорилтын хүрээнд 17 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 83.0 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Д.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
			/төгрөгөөр/
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	185,151,239.22	205,670,616.76
1.1.2	Дансны авлага	906,350,009.25	812,943,963.30
1.1.6	Бараа материал	314,891,687.94	313,358,911.07
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	14,477,878.66	3,487,115.94
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,420,870,815.07	1,335,460,607.07
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	9,867,833,839.87	9,106,080,949.02
1.2.2	Биет бус хөрөнгө	11,653,162,112.80	11,652,800,800.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	21,520,995,952.67	20,758,881,749.02
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	22,941,866,767.74	22,094,342,356.09
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	262,407,431.24	235,195,856.99
2.1.1.3	Татварын өр	300,080,619.35	308,808,368.27
2.1.1.4	НДШ-ийн өглөг	432,476,563.27	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	224,479,270.94	13,419,630.20
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,219,443,884.80	557,423,855.46
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	3,731,110,140.00	3,731,110,140.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	3,731,110,140.00	3,731,110,140.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	4,950,554,024.80	4,288,533,995.46
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	2,637,320,333.16	2,637,320,333.16
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,888,197,225.37	1,888,197,225.37
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	12,742,841,086.40	12,742,841,086.40
2.3.9	Хуримтлагдсан ашиг	722,954,098.01	537,449,715.70
2.3.11	Эздийн өмчийн дүн	17,991,312,742.94	17,805,808,360.63
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	22,941,866,767.74	22,094,342,356.09

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
			/төгрөгөөр/
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,847,217,958.10	3,262,344,231.19
2	Борлуулалтын өртөг	39,352,142.82	21,042,385.03
3	Нийт ашиг (алдагдал)	3,807,865,815.28	3,241,301,846.16
4	Түрээсийн орлого	84,400,000.00	78,000,000.00
5	Хүүгийн орлого	1,107,643.74	-
8	Бусад орлого	344,066,956.50	87,827,448.83
10	Ерөнхий ба удирдлагын зардал	4,735,689,312.24	3,544,508,570.01

13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	6,237,994.73	(792,353.02)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(148,503.06)	(54,067,545.20)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(492,159,405.05)	(192,239,173.24)
19	Орлогын татварын зардал	110,758.87	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(492,270,163.92)	(192,239,173.24)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,637,320,333.16	1,888,197,225.37	12,740,903,531.19	1,215,904,261.93	18,482,325,351.65
Залруулсан үлдэгдэл	2,637,320,333.16	1,888,197,225.37	12,740,903,531.19	1,215,904,261.93	18,482,325,351.65
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	1,937,555.21	-	1,937,655.21
Зарласан ногдол ашиг	-	-	-	(680,000.00)	(680,000.00)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(492,270,163.92)	(492,270,163.92)
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,637,320,333.16	1,888,197,225.37	12,742,841,086.40	722,954,098.01	17,991,312,742.94
Залруулсан үлдэгдэл	2,637,320,333.16	1,888,197,225.37	12,742,841,086.40	722,954,098.01	17,991,312,742.94
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	6,734,790.93	6,734,790.93
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(192,239,173.24)	(192,239,173.24)
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,637,320,333.16	1,888,197,225.37	12,742,841,086.40	537,449,715.70	17,805,808,360.63

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,396,612,069.52	3,235,637,979.25
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	3,321,173,488.78	3,235,637,979.25
	Бусад мөнгөн орлого	75,438,580.74	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,529,329,447.67	3,220,379,291.75
	Ажиллагчдад төлсөн	2,064,549,028.46	1,348,434,426.42
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	294,991,232.00	873,335,212.95
	Бараа материал худалдан авахад төлсөн	121,832,519.00	355,104,717.44
	Ашиглалтын зардалд төлсөн	7,947,430.81	-
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	27,000,000.00	-
	Татварын байгууллагад төлсөн	52,565,566.00	214,194,452.26
	Даатгалын төлбөрт төлсөн	5,001,728.00	-
	Бусад мөнгөн зарлага	955,441,943.40	429,310,482.68
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(132,717,378.15)	15,258,687.50
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	12,827,000.00	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	12,827,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(12,827,000.00)	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	25,067,095.37	6,053,038.90
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	25,067,095.37	6,053,038.90
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	25,067,095.37	6,053,038.90
4	Валютын ханшийн зөрүү	6,237,994.73	(792,348.86)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(114,239,288.05)	20,519,377.54
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	299,390,527.27	185,151,239.22
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	185,151,239.22	205,670,616.76

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 он		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	сая/төг	4,283.4	4,031.9	3,428.2	(603.7)	85.0
	Захиалагчийн техник хяналтын орлого	сая/төг	2,023.5	2,711.4	1,864.5	(846.8)	68.8
	Зураг төсөл магадлалын орлого	сая/төг	601.3	400.0	552.1	152.1	138.0
	Лабораторийн үйл ажиллагааны орлого	сая/төг	299.4	286.4	271.1	(15.3)	94.7
	Сургалтын орлого	сая/төг	663.4	450.0	535.5	85.5	119.0
	Техник ашиглалт, хяналтын орлого	сая/төг	259.7	39.0	39.0	-	100.0
	Борлуулалтын орлого	сая/төг	3,847.2	3,886.8	3,262.3	(624.5)	83.9
	Түрээсийн орлого	сая/төг	84.4	78.0	78.0	-	100.0
	Хүүгийн орлого	сая/төг	1.1	-	-	-	-
	Бусад орлого /Хэвлэх цех, ҮҮА /	сая/төг	350.7	67.1	87.8	20.7	130.9
2	Нийт зардал	сая/төг	4,775.6	4,031.6	3,620.4	(411.2)	89.8
	Үүнээс: удирдлагын зардал	мян/төг	181.4	146.9	137.9	(9.0)	93.9
3	Татварын өмнөх ашиг (алдагдал)	сая/төг	(492.3)	0.3	(192.2)	(192.5)	(72,447.2)
4	Цэвэр ашиг (алдагдал)	сая/төг	(492.3)	0.3	(192.2)	(192.5)	(80,496.9)
5	Төрийн өмчийн ногдол ашигт	сая/төг	0.7	-	-	-	-
6	Нийт ажиллагсдын тоо	тоо	119.0	96.0	96.0	-	100.0
7	Нийт цалингийн сан	сая/төг	2,369.7	1,663.0	1,644.6	(18.3)	98.9
8	Нэг ажилтны дундаж цалин	сая/төг	1.7	1.4	1.4	-	98.9
9	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.1	1.0	1.1	0.1	105.6
10	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая/төг	78.0	52.0	2.4	(49.6)	4.6
11	Нийт авлага	сая/төг	906.4	839.8	812.9	(26.9)	96.8
	Үүнээс: Найдваргүй	сая/төг	592.7	592.7	592.7	-	100.0
12	Нийт өр төлбөр	сая/төг	4,950.6	5,200.4	4,288.5	(911.8)	82.5
	Богино хугацаат өр төлбөр	сая/төг	1,219.4	1,469.3	557.4	(911.8)	37.9
	Урт хугацаат өр төлбөр	сая/төг	3,731.1	3,731.1	3,731.1	-	100.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 25-аас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн аудитор Ч.Оюундулам, аудиторын туслах Б.Бүрэнжаргал нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Ч.Энхчимэг, чанарын хяналтын менежер Д.Мядагмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 1/67 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний А/89 тоот тушаалаар шинэчлэн баталсан байна.

Тайлант онд тус байгууллагын 2020, 2021 эхний хагас жилийн байдлаар Шилэн дансны үйл ажиллагаанд Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас дотоод хяналт, шалгалт хийсэн байна.

ТӨБЗГ-ын 2021 оны 50 дугаар тогтоолын дагуу Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ нь шинээр 9 ажилтны орон тоотой Дотоод аудит, хяналт шинжилгээний хэлтэстэй болсон байна. Тухайн хэлтэс нь 6 дугаар сараас эхлэн хэлтсийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Захирлын 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдөр баталсан удирдамжийн дагуу төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж, хэлтсүүдийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүү байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 22,941.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 229.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ-ын зорилго нь эрчим хүчний салбарт улсын төсвийн болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл тусламжаар хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавих, эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх, дүгнэлт гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрчим хүчний салбарт улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, концесс, гадаад хамтын ажиллагаа болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд гэрээгээр ажил үйлчилгээ гүйцэтгэх, захиалагчийн хяналт тавих;
- Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийж дүгнэлт гаргахтай холбогдох бусад ажлуудыг зохион байгуулах;
- Эрчим хүчний салбарын ажилтныг мэргэжил эзэмшүүлэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшсэн, зөвлөх инженерийн зэрэг олгох, төсөвчний анхан шатны болон зэрэг олгох сургалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих, магадлан итгэмжлэх;
- Эрчим хүчний салбарын ажилтан, ажиллагсдын мэргэжлийн болон мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, сургалтын анги, танхим, лаборатори, сургагч багшийн үйл ажиллагаанд хяналт шалгалт тавих, баталгаажуулах, магадлан итгэмжлэх;
- Цахилгаан болон дулаанжуулалтын зуух, турбин тоноглолын найдвартай байдлыг хангах зорилгоор эрчим хүчний салбарын сорил, шинжилгээний нэгдсэн лаборатори ажиллуулах;
- Эрчим хүчний барилга байгууламж, зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус комиссыг ажиллуулах;
- Орон тооны бус комиссын гаргасан дүгнэлтийг үндэслэн Эрчим хүчний сайдын тушаалаар тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг явуулна;
- Иргэн, хуулийн этгээдийн эрчим хүчний бодит хэрэглээ, эрчим хүчний зардал, барилга байгууламжийн хийцэд тооцоо судалгаа, дүн шинжилгээ хийх, хэмнэх боломжийн талаар ерөнхий дүгнэлт боловсруулах, зөвлөмж гаргах, үр дүнг тайлагнах;

- Эрчим хүчний чиглэлээр олон улсын болон дотоодын хурал, уулзалт зохион байгуулах, оролцох, туршлага судлах;
- Эрхлэх асуудлаараа хууль тогтоомжид нийцүүлэн гадаад дотоодын болон олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, санамж бичиг, гэрээ хэлцэл байгуулах, мэдээлэл солилцох, түүний хэрэгжилтийг хангах, хөтөлбөр, үйл ажиллагааг зохион байгуулах;
- Үйлдвэрийн газраас техник хяналт тавигдсан эрчим хүчний барилга байгууламжийн техникийн хяналт, зураг төсөвтэй холбоотой мэдээллийн сан бүрдүүлэх;

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэж статусыг тодорхойлсон байна. Өмчийн 100 хувийг төр, үүнээс ТӨБЗГ 100 хувийг эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ нь Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 51 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага буюу захирлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18.1 "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана. Захирлыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, зохих салбар, хүрээний яам, агентлагтай зөвшилцөн томилох буюу өөрчилнө" гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд байгууллага дүрмийн хүрээнд хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг, зорилго, зорилтод тулгуурлаж ажлын байрны хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, түүнд үндэслэн орон тоо, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой зохион байгуулах саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, 2021 оны 50 дугаар тогтоолоор батлуулсан. Мөн төвийн Захирлын 2021 оны 8 дугаар сарын 12-ны А/30 тоот тушаалаар байгууллагад мөрдөгдөж байгаа дүрэм, журмуудыг Засгийн газрын шийдвэрээр шинэчлэгдсэн холбогдох хууль, дүрэм, журмуудтай уялдуулан шинэчилсэн байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг ТӨБЗГ-ын 2021 оны 50 дугаар тогтоолоор өөрчилж, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог 30 нэгжээр бууруулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулж ТӨБЗГ контрактын биелэлтийг дүгнэж тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Захирлын 2021 оны 07 дугаар сарын 29-ний А/23 тушаал “Хөдөлмөрийн дотоод журам”
- Захирлын 2021 оны 11 дүгээр сарын 22-ны А/71 тушаал “Автомашин ашиглах журам”

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	185,151.2	205,670.7	20,519.5
Авлага	906,350.0	812,944.0	(93,406.0)
Урьдчилгаа	14,477.9	3,487.1	(10,990.8)
Бараа материал	314,891.7	313,358.9	(1,532.8)
Үндсэн хөрөнгө	9,867,833.9	9,106,080.9	(761,753.0)
Биет бус хөрөнгө	11,653,162.1	11,652,800.8	(361.3)
Нийт хөрөнгийн дүн	22,941,866.8	22,094,342.4	(847,524.4)
Богино хугацаат өглөг	1,219,443.9	557,423.9	(662,020.0)
Урт хугацаат өглөг	3,731,110.1	3,731,110.1	-
Эздийн өмч	17,991,312.8	17,805,808.4	(185,504.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	22,941,866.8	22,094,342.4	(847,524.4)

Касс дахь бэлэн мөнгө 0.6 сая, банк дахь харилцах дансанд 205.1 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 45.1 сая төгрөгийн, шүүхээр шийдвэрлүүлж буй ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор барилгын ажил гүйцэтгүүлэхээр “Түмэн-Алт” ХХК-тай байгуулсан 2014 оны гэрээний 365.7 сая төгрөг, “Ханлиг илч” ХХК-ийн 2015 оны сургалтын төлбөрийн 3.6 сая төгрөг, “Амтат тогоо” ХХК-ийн 2014 оны түрээсийн төлбөрийн 5.8 сая төгрөг болон хугацаа хэтэрсэн 2017-2012 онд Эрчим хүчний газар байх үед үүссэн, балансаас баланст шилжиж ирсэн 592.7 сая төгрөгийн найдваргүй авлага байна. 2017 онд 200.0 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулсан нь өөрчлөгдөөгүй байна.

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд 14.5 сая төгрөг байснаас тооцоо дуусаагүй бүртгэлд үлдсэн 3.1 сая төгрөгийн ажил нь шүүхийн маргаан дуусаагүй шалтгаанаас өөрчлөгдөөгүй байна. Тайлант онд ажлын төлбөрт 144.4 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлж, ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэж 155.4 сая төгрөгийг зардалд хүлээн зөвшөөрсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 313.3 сая төгрөг болж 1.6 сая төгрөгөөр буурсан нь бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, нөөц нэмэгдүүлэн үүсгээгүйгээс шалтгаалжээ. Дансны үлдэгдэлд хадгалах, ашиглах хугацаа дууссан, тусгай аргаар устгах шаардлагатай 6.3 сая төгрөгийн химийн бодис багтаж байна.

Үндсэн хөрөнгө ТӨБЗГ-ын 2021 оны 415 дугаар тогтоолоор акталсан 144.8 сая, ТӨБЗГ-ын 2021 оны 204 дүгээр тогтоолоор Монгол улсын их сургуулийн харьяа Шинжлэх ухааны сургуульд балансаас баланст шилжүүлсэн 122.0 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр хасагджээ.

Биет бус хөрөнгө 0.4 сая төгрөг хорогдлын дүнгээр буурсан байна.

Дуусаагүй барилга дансны үлдэгдэлд 3,799.5 сая төгрөг нь тус байгууллага үүсгэн байгуулагдахад шилжин ирсэн эхлэлтийн баланс дахь Эгийн голын усан цахилгаан станцаас шилжин ирсэн үлдэгдэл байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 557.4 сая төгрөгийн өр төлбөр байна. Өмнөх онтой харьцуулахад 662.0 сая төгрөгөөр буурсан нь он дамжин хуримтлагдсан нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн төлж, хувь хүний орлогын татварын тухайн оны өр төлбөрийг бүрэн барагдуулсантай холбоотой байна.

Урт хугацаат хугацаат өр төлбөрт Эгийн голын усан цахилгаан станц төслийг хэрэгжүүлэх зорилгоор Сангийн яам болон Эрчим хүчний судалгаа хөгжлийн төв ТӨААТҮГ-ын хооронд 2006 онд байгуулсан гэрээгээр үүссэн 3,731.1 сая төгрөгийн өр байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад 1,209.5 сая төгрөгөөр хасагдсан нь Ковид цар тахлаас шалтгаалж сул зогсолттой байсан ба орон тоо буурч, цалингийн зардал багассанаас шалтгаалжээ.

Эздийн өмч дансны үлдэгдэл 185.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны алдагдал 192.2 сая төгрөг болон өмнөх оны гэрээ хэрэгжээгүй 6.4 сая төгрөгийн залруулгаас шалтгаалсан байна

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 680 дугаар тогтоолоор Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 5,041.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 5,035.2 сая төгрөгөөр, 6.2 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 239.4 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 394 дугаар тогтоолоор нийт орлогыг 4,031.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 4,031.6 сая төгрөгөөр, 0.3 сая төгрөгийн ашигтай байхаар тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 3,428.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,620.4 сая төгрөгийн зардал гарган, 192.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 4,031.9 сая төгрөг болж төлөвлөснөөс 3,428.2 сая төгрөг буюу 14.97 хувиар тасарсан нь дэлхий даяар тархсан Ковид-19 цар тахлын улмаас зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгждэг төсөл, арга хэмжээний санхүүжилт удааширч, Засгийн газрын шийдвэрүүдийн дагуу хилийн бүх боомтоор улсын хил нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2021 оны 8 дугаар сарын 31-ний өдрийг дуустал түр зогсоосон, бараа материалын эргэлт, татан авалт удааширч томоохон төслүүдийн хэрэгжилт удааширсан Засгийн газрын шийдвэрүүдээс шалтгаалж сургалтын үйл ажиллагааг хязгаарласан, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад батлагдсан Эрчим хүчний сайдын багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийн нийт санхүүжих дүн нь 54,592.5 сая төгрөг байсан ба 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр 38,052.8 сая төгрөг болгож буурсан зэрэг нь нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 3,620.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 411.2 сая төгрөг буюу 10.2 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь Ковид-19 цар тахлын улмаас орлого буурч гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 1 нэр төрлийн 1 ажилд өөрийн эх үүсвэрээс 2.4 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд алдагдал 192.2 сая төгрөг болсон нь төгрөгөөр дутуу байгаа нь орлого тасалдалт нөлөөлж байна.

ТӨБЗГ-ын 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 228 тоот тогтоолд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь хэмжээг тогтоосон ба Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ 2020 онд алдагдалтай ажилласан тул тухайн тогтоолд тусгагдаагүй. Мөн ТӨБЗГ-т түрээсийн төлбөрийн 40 хувь болох 31.2 сая төгрөгийн түрээсийн төвлөрүүлэх орлогоос 15.0 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ нь тайлант онд шилэн дансны цахим хуудсанд хуулийн дагуу байршуулах 149 мэдээллээс 143 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтсан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 1,006.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 994.3 сая төгрөгийг залруулж, 12.4 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 279.7 сая төгрөгийн зөрчилд 78.1 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 201.6 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгснөөс албан шаардлага 100.0 хувь, зөвлөмж 75.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	78.1	2	78.1	-	-	100.0
Зөвлөмж	4	201.6	3	201.6	1	-	75.0
Нийт дүн	6	279.7	5	279.7	1	-	83.3

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 83.3 хувьтай байна. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу НӨАТ суутган төлөгч байгууллагад бүртгүүлж үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд эрхлэн явуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дээд шатны захирагчийн анхааралд хандуулах дараах асуудлууд байна. Үүнд:

1. Санхүүгийн тайланд тайлагнасан авлагын дүнд Эрчим хүчний газар байх үед үүссэн аж ахуй нэгж, хувь хүнтэй холбоотой 2007-2012 онд үүссэн балансаас баланст Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ үүсгэн байгуулагдахад шилжиж ирсэн 592.7 сая төгрөгийн авлагыг тухайн үед нь тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүйгээс өнөөдрийг хүртэл шийдвэрлэгдээгүй, эзэн холбогдогч тодорхойгүй, Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ нь шүүхэд хандсан боловч эзэн холбогдогч тодорхой бус шалтгаанаар буцаагдсан;

2. Эгийн голын усан цахилгаан станц төслийг хэрэгжүүлэх зорилгоор Сангийн Яам болон Эрчим хүчний судалгааны Хөгжлийн төв ТӨААТҮГ-ын хооронд 2006 оны 11-р сарын 27-ны өдөр байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээтэй холбоотой үүссэн 3,731.1 сая төгрөгийн урт хугацаат өглөгийн үлдэгдэл байна. Гэрээний дүн 3.8 сая ам.доллар байх бөгөөд тус байгууллагын баланст эхлэлтийн балансаар шилжиж ирсэн үеийн 3,731.1 төгрөгөөр бүртгэгдэж ханшийн тэгшитгэл хийгээгүй ирсэн байна. Энэ нь УИХ-ын 2010 оны 12 сарын 09-ны өдрийн Түлш, эрчим хүчний салбарын талаар авах арга хэмжээний тухай 72 дугаар тогтоолын 1.1-д “Эрчим хүчний салбарын төрийн өмчийн компаниудын урт хугацаат зээлийг анх зээлсэн үеийн ханшаар тооцон өртөгт шилжүүлэх, ханшийн зөрүүнээс үүссэн алдагдлыг Засгийн газар бүрэн хариуцаж тухайн салбарт оруулсан хөрөнгө оруулалт болгон тооцох, цаашид урт хугацаат зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг барагдуулах асуудлыг судлах” гэснийг үндэслэн төгрөгөөр бүртгэж, өнөөдрийг хүртэл ханшийн тэгшитгэл хийгээгүй байна. Сангийн яамны 2020 оны 12 сарын 30-ны 8-3/8031 тоот дамжуулан зээлийн өглөгийг санхүүгийн тайланд бүртгэх тухай албан бичгээр 6,769.7 сая төгрөгийн өглөг дурдагдсан байна. Цаашид УИХ-ын 2010 оны 12 сарын 09-ны өдрийн Түлш, эрчим хүчний салбарын талаар авах арга хэмжээний тухай 72 дугаар тогтоолын 1.1-д “Эрчим хүчний салбарын төрийн өмчийн компаниудын урт хугацаат зээлийг анх зээлсэн үеийн ханшаар тооцон өртөгт шилжүүлэх, ханшийн зөрүүнээс үүссэн алдагдлыг Засгийн газар бүрэн хариуцаж... дагуу Засгийн газартай тооцоо нийлж, яам хоорондын тооцоог цэгцлэх” гэж заасны дагуу тооцоо нийлж, урт хугацаат өглөгийн зөрүүг шийдвэрлэх.

Дараагийн аудитаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 12 сарын 06-ны 659 дугаар магадлалаар 2012-2016 оны татварын хяналт шалгалтын актаар 1,550.8 сая төгрөгийн төлбөрийг төлүүлэхээр актыг өөрчлөн тогтоосон нь эцэслэн шийдвэрлэгдээгүй асуудлыг авч үзнэ

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,022.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,005.2 сая төгрөгийн алдааг залруулж, 1.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 16.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн.

Залруулагдаагүй 17.3 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 229.4 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1,005.2 сая төгрөгийн 9 алдааг залрууллаа. Үүнд:

- Нийгмийн даатгалын цахим системийн мэдээллийг нягтлан бодох бүртгэлийн журналын бичилттэй тулгахад нийт цалингийн дүн 2.0 сая төгрөгөөр зөрүүтэй;
- Хувь хүний орлогын албан татварын тайланг санхүүгийн программын бичилттэй тулгахад ХХОАТ-н 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй илгээгдсэн;
- Санхүү байдлын тайлан дахь өглөг, авлагын дүнг тооцоо нийлсэн акттай тулган баталгаажуулахад авлага 4.3 сая, өглөг 1.1 сая төгрөгийн зөрүүтэй бүртгэгдсэн;
- Үндсэн хөрөнгийн элэгдэл 3.3 сая төгрөгөөр зөрүүтэй тооцоолсон;
- Цахим баримтын ebarimt.mn системд шивэгдсэн баримтыг тулгахад худалдан авалтын 124.3 сая, борлуулалтын 793.0 сая төгрөгийн и-баримт дутуу шивэгдсэн;
- Санхүүгийн тайлангийн төрийн өмчийн дүн 17.0 сая төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн;
- Шилэн дансанд 60.0 сая төгрөгийн 3 гүйлгээний мэдээллийг байршуулаагүй.

8.2 Төлбөрийн акт

Нийгмийн даатгалын тайланг бодогдсон цалингийн зардлаас 0.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээн”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 “Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” 17.1.3 “Нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Төлбөрийн акт тогтоох.

Шатахууны зарцуулалтыг жишиг нормын дагуу тооцоолоход 0.2 сая төгрөгийн шатахууныг норм хэтрүүлэн зарцуулсан нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад тусгагдсан “Авто машины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 14 дүгээр зүйлийн 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д аж ахуйн бүх ажил, гүйлгээ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Төлбөрийн акт тогтоох.

Томилолтын зардлыг анхан шатны баримттай тулган баталгаажуулахад 0.5 сая төгрөгийн баримт дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 “Анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6 “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Төлбөрийн акт тогтоох.

8.3 Албан шаардлага

Цахим баримтын ebarimt.mn системд шивэгдсэн баримтыг худалдан авалтын баримтуудтай тулгахад 12.4 сая төгрөгийн и-баримт дутуу байгаа нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д “Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Албан шаардлага хүргүүлэх.

Санхүү байдлын тайлан дахь авлага, өглөгийн дүнг тооцоо нийлсэн акттай тулгахад 2.3 сая төгрөгийн авлага, 1.6 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх” зарчим, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” 20 дугаар зүйлийн 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Албан шаардлага хүргүүлэх.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу НӨАТ суутган төлөгч байгууллагаар бүртгүүлж үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд эрхлэн явуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-д “Үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, албан татвар ногдуулан суутган авч, төсөвт төвлөрүүлэх үүрэг бүхий дараах этгээд албан татвар суутган төлөгч байна”, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Албан шаардлага хүргүүлэх.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 680 дугаар тогтоолоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 5,041.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 5,035.2 сая төгрөгөөр, ашгийг 6.2 сая төгрөг байхаар баталсан байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 394 дүгээр тогтоолоор нийт орлогыг 1,009.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,003.6 сая төгрөг, ашгийг 5.9 сая төгрөгөөр тус тус бууруулж тодотгосон байна. Гүйцэтгэлээр 3,428.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,620.4 сая төгрөгийн зардал гарган, 192.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Албан шаардлага хүргүүлэх.

Дээрх акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Эрчим хүчний хөгжлийн төв	АХГ-2022/108/НА-СТА-ТӨА	Нийгмийн даатгалын тайланг бодогдсон цалингийн зардлаас зөрүүтэй тайлагнасан.	Холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлэх	1	248.2			1	248.2						
2	Эрчим хүчний хөгжлийн төв	АХГ-2022/108/НА-СТА-ТӨА	Шатахууны зарцуулалтыг жишиг нормын дагуу тооцоолоход шатахууны норм хэтрүүлэн зарцуулсан байна.	Холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлэх	1	230.7			1	230.7						
3	Эрчим хүчний хөгжлийн төв	АХГ-2022/108/НА-СТА-ТӨА	Томилолтын зардлыг анхан шатны баримттай тулган баталгаажуулахад анхан шатны баримтгүй байна.	Холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлэх	1	498.4			1	498.4						
4	Эрчим хүчний хөгжлийн төв	АХГ-2022/108/НА-СТА-ТӨА	Цахим баримтын ebarimt.mn системийн баримтууд дутуу шивэгдсэн зөрчил илэрсэн.	ebarimt.mn системд баримтыг нөхөн авах	1	12,441.8					1	12,441.8				
5	Эрчим хүчний хөгжлийн төв	АХГ-2022/108/НА-СТА-ТӨА	Авлага тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	Тооцоо нийлж баталгаажуулах	1	2,260.7					1	2,260.7				
6	Эрчим хүчний хөгжлийн төв	АХГ-2022/108/НА-СТА-ТӨА	Өглөг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	Тооцоо нийлж баталгаажуулах	1	1,588.6					1	1,588.6				
7	Эрчим хүчний хөгжлийн төв	АХГ-2022/108/НА-СТА-ТӨА	НӨАТ суутган тооцоогүй	НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлэх	1	-					1	-				
8	Эрчим хүчний хөгжлийн төв	АХГ-2022/108/НА-СТА-ТӨА	Нийгмийн даатгалын цахим системийн мэдээллийг нягтлан бодох бүртгэлийн журналын бичилттэй тулгахад нийт цалингийн дүн зөрүүтэй байна.	Цалингийн зардал, нийгмийн даатгалын зардлыг зөв дүнгээр тусгаж, журнал бичилтийг залруулав	1	1,952.4	1	1,952.4								
9	Эрчим хүчний хөгжлийн төв	АХГ-2022/108/НА-СТА-ТӨА	Хувь хүний орлогын албан татварын тайланг санхүүгийн программын бичилттэй тулгахад ХХОАТ-н зөрүүтэй илгээгдсэн байна.	ХХОАТ-ын тайланг засварлаж илгээв	1	202.2	1	202.2								

10	Эрчим хүчний хөгжлийн төв	АХГ-2022/108/НА-СТА-ТӨА	Санхүү байдлын тайлан дахь авлагын дүнг тооцоо нийлсэн акттай тулган баталгаажуулахад авлага гэрээ гүйцэтгэлийн актаас зөрүүтэй бүртгэгдсэн байна.	Авлагын дүнг зөв болгож залруулав.	1	4,334.8	1	4,334.8										
11	Эрчим хүчний хөгжлийн төв	АХГ-2022/108/НА-СТА-ТӨА	Санхүү байдлын тайлан дахь өглөгийн дүнг тооцоо нийлсэн акттай тулган баталгаажуулахад өглөг зөрүүтэй бүртгэгдсэн байна	Өглөгийн дүнг зөв болгож залруулав.	1	1,068.9	1	1,068.9										
12	Эрчим хүчний хөгжлийн төв	АХГ-2022/108/НА-СТА-ТӨА	Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг зөрүүтэй тооцоолсон.	Элэгдлийг залруулав.	1	3,335.3	1	3,335.3										
13	Эрчим хүчний хөгжлийн төв	АХГ-2022/108/НА-СТА-ТӨА	Цахим баримтын ebarimt.mn системийн худалдан авалтын баримтууд дутуу шивэгдсэн зөрчил илэрсэн.	ebarimt.mn системд худалдан авалтын баримтыг нөхөж авав.	1	124,278.2	1	124,278.2										
14	Эрчим хүчний хөгжлийн төв	АХГ-2022/108/НА-СТА-ТӨА	Цахим баримтын ebarimt.mn системийн борлуулалтын орлогын баримтууд дутуу шивэгдсэн зөрчил илэрсэн.	ebarimt.mn системд борлуулалтын баримтыг нөхөж шивүүлэв.	1	793,000.0	1	793,000.0										
15	Эрчим хүчний хөгжлийн төв	АХГ-2022/108/НА-СТА-ТӨА	Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл дутуу байршуулсан байна.	Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг нөхөж байршуулав	1	60,000.0	1	60,000.0										
16	Эрчим хүчний хөгжлийн төв	АХГ-2022/108/НА-СТА-ТӨА	Байгууллагын төрийн өмчийн дүн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэгдсэн өөрийн хөрөнгийн хэмжээ зөрүүтэй.	Улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулав	1	17,000.0	1	17,000.0										
ДҮН					16	1,022,440.2	9	1,005,171.8	3	977.3	4	16,291.1						
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																		
1	Эрчим хүчний хөгжлийн төв	АХГ-2022/108/НА-СТА-ТӨА	Шилэн дансны цахим хуудсанд 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах	1	-											1	-
2	Эрчим хүчний хөгжлийн төв	АХГ-2022/108/НА-СТА-ТӨА	2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь гүйцэтгэлээр 3,428.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,620.4 сая төгрөгийн зардал гарган, 192.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.	Батлагдсан төлөвлөгөөг хангаж ажиллах	1	-					1	-						
ДҮН					2	-					1	-					1	-
НИЙТ ДҮН					18	1,022,440.2	9	1,005,171.8	3	977.3	5	16,291.1					1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 462/А0150055
АХГ-2022/108/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд байгууллагын шилэн дансны цахим мэдээллийн системд хуулийн дагуу байршуулах 149 мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-д заасныг үндэслэн хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын Захирал Я.Нямжаргал, Ерөнхий нягтлан бодогч Д.Эрдэнэчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ч.ЭНХЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 463/А0150055
АХГ-2022/108/АА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу НӨАТ суутган төлөгч байгууллагаар бүртгүүлж, үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд эрхлэн явуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 “Үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, албан татвар ногдуулан суутган авч, төсөвт төвлөрүүлэх үүрэг бүхий дараах этгээд албан татвар суутган төлөгч байна”, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу НӨАТ суутган төлөгч байгууллагаар бүртгүүлж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын Захирал Я.Нямжаргал, Ерөнхий нягтлан бодогч Д.Эрдэнэчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СИ ПИ ТИ ЭИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ч.ЭНХЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 464/А0150055

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүү байдлын тайлан дахь өглөгийн дүнг тооцоо нийлсэн акттай тулгахад 1,588,587.20 төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх" зарчим, 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Баталгаажуулаагүй өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын Захирал Я.Нямжаргал, Ерөнхий нягтлан бодогч Д.Эрдэнэчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ч.ЭНХЧИМЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 495/А0150055
АХГ-2022/108/НА-СТА-Т0А

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 680 дугаар тогтоолоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 5,041,445.3 мянган төгрөгөөр, нийт зардлыг 5,035,166.5 мянган төгрөгөөр, ашгийг 6,278.8 мянган төгрөг байхаар баталсан байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 394 дүгээр тогтоолоор нийт орлогыг 1,009,552.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,003,539.3 мянган төгрөг, ашгийг 6,013.4 мянган төгрөгөөр тус тус бууруулж 265.4 мянган төгрөгийн ашигтай ажиллагааар тодотгосон байна. Гүйцэтгэлээр 3,428,171.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 3,620,410.9 мянган төгрөгийн зардал гарган, 192,239.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийг батлагдсан төлөвлөгөөний дагуу хангаж ажиллах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын Захирал Я.Нямжаргал, Ерөнхий нягтлан бодогч Д.Эрдэнэчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ч.ЭНХЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 105/А0150055

Улаанбаатар хот

АХГ-2022/108/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цахим баримтын ebarimt.mn системд 12,441,810.00 төгрөгийн худалдан авалтын бүртгэлгүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 “Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тусшаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. И-баримтын бүрдэл хангаагүй ажил, гүйлгээ гаргасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын Захирал Я.Нямжаргал, Ерөнхий нягтлан бодогч Д.Эрдэнэчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СИ ПИ ТИ ЭИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ч.ЭНХЧИМЭГ

001090241



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 102/А0150055
АХГ-2022/108/НА-СТА-ТӨЖ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Санхүү байдлын тайлан дахь авлагын дүнг тооцоо нийлсэн акттай тулгахад 2,260,689.50 төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх" зарчим, 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Баталгаажуулаагүй авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын Захирал Я.Нямжаргал, Ерөнхий нягтлан бодогч Д.Эрдэнэчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ч.ЭНХЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 101/А.0150055

Улаанбаатар хот

АХГ-2022/108/НА-СТА-ТВА
Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын 2021 оны томилолтын зардлыг анхан шатны баримттай тулган баталгаажуулахад 498,409.00 төгрөгийн зардал анхан шатны баримтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 "Анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.-д заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Анхан шатны баримтгүй 498,409.00 /Дөрвөн зуун ерөн найман мянга дөрвөн зуун ес/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын захирал Я.Нямжаргал, Ерөнхий нягтлан бодогч Д.Эрдэнэчимэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ч.ЭНХЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 104/А0150055

Улаанбаатар хот

АХГ-2022/108/НА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шатахууны зардлыг жишиг нормын дагуу тооцоолоход 230,688.00 төгрөгийн шатахууны норм хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйлийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1 "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад тусгагдсан "Авто машины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Шатахууны зардлыг жишиг нормыг хэтрүүлэн илүү тооцож олгосон 230,688.00 /Хоёр зуун гучин мянга зургаан зүүн наян найм/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 03 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын Захирал Я.Нямжаргал, Ерөнхий нягтлан бодогч Д.Эрдэнэчимэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ч.ЭНХЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 103/А0150055

Улаанбаатар хот

АХГ-2022/108/КА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын 2021 оны нийгмийн даатгалын тайланг бодогдсон цалингийн зардлаас зөрүүтэй тайлагнаж, 248,220.00 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал илүү үүсгэсэн байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1 аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээн", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", 17.1.3 "Нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү тооцсон 248,220.00 /Хоёр зуун дөчин найман мянга хоёр зуун хорь/ төгрөгийн зардлыг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг "Эрчим хүчний хөгжлийн төв" ТӨҮГ-ын Захирал Я.Нямжаргал, Ерөнхий нягтлан бодогч Д.Эрдэнэчимэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ч.ЭНХЧИМЭГ